ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 07 дугаар Дугаар ... Улаанбаатар хот
сарын ...-ны өдөр

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор батлсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, “Эх голомтын илч” ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 36 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар батлсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Эх голомтын илч” ХХК (Ч.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 222 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны 07 дугаар сарын ...-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөв болон үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	төг/м^3	2,790.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна.)	төг/м^2	1,400.0

---oOo---